

Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРСАМЖ

АЛТАН АРСАМЖ

VOL.3

1/2000

ХҮН ТӨРӨЛХТӨНИЙ ТҮҮХ БОЛ НҮҮДЛИЙН ТҮҮХ МӨН

МУИС, ОУХС,
дэд доктор Я.Ганбаатар,
дэд доктор Д.Энхбат

Төв Азийн өндөрлөг уудам бүс нутаг бол хүмүүн төрөлхтөний үүсэн буй болсон анхдагч голомт мөн гэсэн үзэл дүгнэлтийг дэлхийн олон эрдэмтэн урьд хожид дэвшүүлэн өөр өөрсдийн судалгааны үр дүн, бодит баримт хийгээд таамаглал магадлалаар баталсаар ирсэн билээ. Өнөөдрийн байдлаар Япон тэнгисээс Каспийн тэнгис, Уралын нуруу хүртэл Умард мөсөн далайгаас Хималайн уулс, Шар мөрний сав газар хүртэл Төв Азийн энэ уудам дэлгэр нутаг дээр нэн эртний хүмүүс үүсэн, сүрэлгэн аж төрж асан голомт, ул мөр хэд хэдээрээ олдож тэмдэглэгдсэн төдийгүй олдвор судлагдахуунаар арвин заримыг нь эрдэмтэд хичээнгүйлэн судалж он цаг болоод ахуйн нөхцлийн талаар нэлээд тоймтой тогтоож чадсан байна.

Тухайлбал ийм голомтууд өнөөгийн Монгол Улс болоод БНХАУ-ын нутаг дэвсгэрийн хойд хэсгээс илэрсэн нь судлаачдын анхаарлыг татдаг бөгөөд БНХАУ-ын дурдсан бүс нутаг бол балар эрт цагаас янагш нүүдэлчин ард түмний уугуул нутаг байсныг хэн ч маргашгүй агаад ер нь дээр дурдсанчлан Төв Азийн уужим дэлгэр бүс нутаг бол хүн төрөлхтөний үүсэн анхдагч голомт төдийгүй хүн төрөлхтөний түүхэн их нүүдэл, хүний тархан салж суурьшсан анхдагч өлгий гэр, цаашлаад хожуу үеийн нүүдэлчин ард түмнүүдийн уугуул нутаг-эх орон нь мөн билээ. Энэ өргөн уудам газар нутаг дээр зөвхөн өнөөгийн хүн буй болсноос хойш эртний Хүн нар, Сүмбэ, Түрэг, Уйгар, Нирун, Хиргис, Хатан, Зурчид... гээд

Монгол, Түрэг олон улс түмэн хүн нийгмийн түүхийн урт удаан хугацааны туршид эрх чөлөөтэй нүүдэллэн аж төрж ирсэн юм. Ер нь өнөөг хүртэл хүний үүсэл гарлыг судлан шинжлэхэд хэд хэдэн газар балар эртний хүний эд өлгийн зүйлийн илрэл бүхий голомт олж тогтоогоод байгаагийн дотроос эрдэмтэд Төв Азийн бүс нутгийг онцлон үздэг юм. Үүнд хэд хэдэн онцлох зүйл бий.

Нэгд: Байгаль газар зүйн боломж

Хоёрт: Цаг уурын нөхцөл байдал

Гуравт: Хүн төрөлхтөний их нүүдлийн улбаа

Дөрөвт: Дээрхтэй уялдан Төв Азийн уугуул иргэд-Монгол төрхөтний тархан нүүдэллэсэн бодит баримт зэрэг болно.

Анх усан далайгаар бүрхмэл байсан манай дэлхийн усан гадарга аажмаар ууршин хуурайшихад хамгийн түрүүн Төв Азийн өндөрлөг тал нутаг ил гарч, чингэснээр дэлхий дээрх амьдрал уснаас хуурай газар руу шилжсэн ул мөр энэ бүс нутгаас хамгийн түгээмэл олддог билээ. Амьдрал асар урт хугацааны туршид үүсч хөгжин, хувьсч өөрчлөгдөж ирсэн энэ зам нэг л эхтэй, нэг л голомттой, өөрөөр хэлбэл гарааны нэг л цэг дээрээс эхэлсэн гэдгийг эрдэмтэд өөр өөрийн судалгаа таамаглалуудаар нотлохыг оролдсоор байна. Тиймээ, амьдрал нэг л цэгээс үүсчээ.

Төв Азийн өндөрлөг бүс нутагт ийнхүү хүн үүсч, улмаар угсаатан бүрэлдсэнээс хойш олон мянган жилийн туршид нүүдэлчин ба суурин иргэдийн соёл иргэншил зэрэгцэн оршоор өнөөг хүрч ирсэн юм. Түүний нэг нь болсон нүүдэлчин ард түмнүүдийн хүрээнд одоогоос долоогоос арван мянган жилийн тэртээд угсаатан болон бүрэлдэж эхэлсэн Ху, Ди нар болоод тэдний удам Хүн нар, Сяньби, Нирун, Түрэг, Уйгар, Хиргис, Хатан, Зурчидийн угсааны улс багтаж, Шар мөрний хойд эрэг хөвөөнөөс Умард мөсөн далай хүртэл, Дорнод Япон тэнгисээс Каспийн тэнгис хүртэлх өргөн уудам газар нутаг дээр овог отог, бүл аймгаараа эвлэлдэн нийлжээ.

Суурьшмал ард түмний хүрээнд гол цөм нь Шар мөрөн, Хөх мөрний хоорондох сав газарт бүрэлдэн соёолсон хятад иргэдийн буй болгосон соёл иргэншил юм.

Төв болоод зүүн өмнөд Азийн өргөн уудам газар нутагт ийнхүү олон мянган жилийн турш зэрэгцэн оршиж ирсэн хоёр өвөрмөц соёл иргэншилд хамаарах олон үндэстэн ястны үүсэл гарал,

хөгжил хувьслын талаар ултай судалж хөдөлбөргүй тогтоох нь нэн сонирхолтой төдийгүй ач холбогдолтой билээ. Энэ асуудлыг гүнзгий суурьтай авч судлах гэвэл даруй 500-700 мянган жилийн түүхийг улбаалан судлах ёстой болно. Өөрөөр хэлбэл Төв Азийн газар нутаг дээр хүний өвөг үүсч буй болоод хөгжин хувьссаар өнөөдөр шинжлэх ухаанд нэрлүүлсэн Протомонголоид буюу Өвөг монголжуу төрхтөн хүн, цаашлаад монголоид буюу монголжуу төрхтөн болон хувьсч одоогоос 40 мянган жилийн тэртээ Палеолит хэмээх хуучин чулуун зэвсгийн үед өнөөгийн бие бялдартай, оюун сэтгэхүйтэй хүн болон хөгжсөн түүхийг сайтар тогтоон судалбал чухал сонин магадлал гарч ирнэ. Тодруулан дурьдвал энэ урт удаан хугацааны турш дахь хүний үүсэл гарал, хөгжил хувьслын түүхийг мөшгихөд их нүүдэл хэмээн нэрлэсэн дэлхий дахинаа хүн төрөлхтөн тархан нүүдэллэсэн гайхамшигтай үйл явцтай салшгүй холбоотой болох нь илэрнэ.

Ийнхүү Төв Азийн өндөрлөг бүс нутагт анхны хүн үүссэн тэр тодорхойгүй эрт бэлэр цагаас эхлэн анхны хүмүүс үргэлжид нүүдэллэн шинэ шинэ нутаг орон тийш тархан суурьшсаар байсан бөгөөд протомонголоид буюу өвөг монголжуу хүмүүсийн үеэс эхлэн тэдний их нүүдлийн улбааг бид багцаа таамгаар болов олж мэдэх бололцоотой байгаа нь цаг хугацааны хувьд одоогоос 500-250 мянган жилийн өмнөх үед хамаарах юм. Энэ үеийн өвөг монголжуу төрхтөн сүрэлгэсэн хүмүүс Евразийн хуурай газраар тархан суурьшиж Европ, Африк тивд хөл тавьж эхэлсэн байна. Харин тэд Америк, Австрали тивийг "нээж" далайн орнууд гэгддэг Номхон далайн олон мянган арал олтриг дээр очиж суурьших хүртэл энэ үеэс хойш бас багагүй цаг хугацаа өнгөрсөн юм.

Төв Азийн өндөрлөг бүс нутагт үүссэн анхны хүн байгаль цаг уурын өөрчлөлтийг даган урагш нүүдэллэн Төв, Өмнөд, Зүүн Азид хүрч улмаар далай орнуудад хүрч чадсан билээ. Тэгвэл Европ тивийн төв хэсгээс Европжуу төрхтөн хүмүүс мөн урагш нүүдэллэн явсаар Африкт хүрч, бас Берингийн тэнгисийг гатлан Төв Азиас хойд Америкт хүрч очсон Монгол төрхтөн нүүдэлчид бүр Өмнөд Америкийн эх газрыг уруудан аялж мөнөөхөн эл хуль асан нэг тив хоёр эх газар дээр анхны хүний мөрийг гаргасан юм. Ийнхүү хүн төрөлхтөний их нүүдэл анх Төв Азиас эхэлсэн гэж эрдэмтэд үздэг бөгөөд өдгөөгөөс 50 мянган жилийн тэртээд Төв Азийн өргөн уудам

тал нутагт оршин аж төрж асан эртний хүмүүс өмнө зүгт нүүдэллэн халуун дулаан орнуудад хүрч тархан суурьшсан мөнөөхөн Их нүүдэл гэгчийн үл мөр, эд баримт бидэнд тодорхой байна. Төв Азиас зүг бүр тийш тархан нүүдэлсэн Монголжуу төрхтөн өнөөдөр Сибирь, Алс Дорнодын Сахалин, Хүрлийн арлууд, Умард туйлын бүс нутгаас гадна Японы арлууд, Солонгосын хойг, Манжуурын тал нутаг, Баруун ба Зүүн өмнөд Ази, түүнчлэн Америк тивийн хоёр эх газар, Номхон далайн олтригууд, Австрали, Шинэ Зеландад оршин сууж байна. Энэ бүхнээс үүдэн хүн төрөлхтөний Их нүүдэл яагаад эхлэх болов? Түүний үндсэн шалтгаан юу байв? Гэдэг асуудал гарч ирнэ. Бэлэр эрт цагаас өнөөг хүртэл манай дэлхий дээр явагдсан Их нүүдэл үндсэн хоёр шалтгаантай байна. Энэ бол:

1. Байгаль цаг уурын шалтгаан
2. Хүн нийгмийн шалтгаан юм.

Байгаль цаг уурын учир шалтгааныг бид ойлгомжтой энгийн үгээр байгалийн шалгарал гэж томъёолъё. Тэгвэл нийгмийн учир шалтгааныг бас дээрхийн адилгаар нийгмийн шалгарал гэж томъёолж болох юм.

Цаг хугацааны хувьд энэ хоёр ойлголт холилдсон бүс дараалсан үйл явц байсан бөгөөд байгалийн шалгарлаар үүдсэн Их нүүдэл нь хүн төрөлхтөний нялх балчир цагт болж өнгөрсөн бол нийгмийн шалгарлаар үүдсэн Их нүүдэл манай тооллын эхэн үеэс эхэлж өнөө ч хүн төрөлхтөн нийгмийн элдэв учир шалтгааны улмаас нүүж суусаар байгаа билээ.

Одоо энэ хоёр үндсэн шалтгааныг задлан тайлбарлав.

Анхны хүний Их нүүдлүүд цэвэр байгаль цаг уурын шинжтэй, нэг үгээр хэлэхэд жамаараа яваа ертөнцийн хөгжил, хувьслын зүй тогтлын дагуу болж байсан байна. Гэхдээ ер нь анхны хүмүүс тогтсон нэг нутаг дээр суурин суугаагүй, цаг улирал, хоол хүнс, ан гөрөөг даган үргэлжид нүүдэллэн аж төрж ирсэн агаад энэ нүүдлийн хүрээ нь Евразийн уудам их газрыг бүхэлд нь хамарч байсан учир заримдаа анхны хүмүүс нүүдлийн шувууд шиг нэг газар нутагтаа эргэн ирдэг байсан бол бас олонхи нь эргэлт буцалтгүй тэр чигтээ улам цаашлан нүүдэллэж тэр цагт хүрч болох бүх л газар оронд хүрч суурьшсан юм.

Байгалийн шалгарал гэгч зөвхөн адгуус амьтанд тохиолддог

байгаль эхийн шалгуур сорилт биш юмсанжээ. Бахархуштай нь хүн гээч амьтан бусад адгуусын төрлүүдийг бодвол их тэсвэр тэвчээртэй, амьдрах чадалтай байсныхаа ачаар алив бүх хүнд бэрх сорилт шалгуурыг даван гарч тэр тоолонгоор улам бүр чангаран чийрэгжиж, ухаалаг оюунлиг болсоор байжээ. Тэгээгүйсэн бол хүн гэдэг ганцхан төрөлтөн, үй олон төрлийн адгуус байгалийн шалгарлыг давж чадалгүй устаж мөхсөн шиг аль хэдийн үгүй болсон байх байсан нь лавтай.

Байгалийн шалгуур тун олон янз, бас тун олон удаа дараалан ирж байлаа. Их мөстлөг, Цөлжилт, Хуурайшил, Хүйтрэлт, Дулааралт тэгснээ эргээд хүйтрэх зэргээр байгаль цаг уурын олон янзын өөрчлөлт хувьсалтуудад дасан зохицох гэж нүүж суун үйл тамаа цайж байх зуур бас гэнэтийн, тэгэхдээ бүр их хөнөөлт үзэгдлүүд тэдний ойлгож тайлж байсанчлан бүрхэн тэнгэр хилэгнэн далдыг ид шидийн хүчээр гэсгээн цээрлүүлэх мэт аймшигт газар хөдлөлт, дорилт, галт уулын дэлбэрэлт, их усны үер, их түймрийн гал нөмрөн авч олноор нь уурд авч одсоор байлаа. Энэ бүхнээс яаж амь гарах вэ? гэдэг асуудал ганц нэгхэн анхны хүний толгойд эргэлдэж байсан бус, энэ бол оюун ухаан сууж ухамсарлан сэтгэх чадвартай болсон анхны хүмүүсийн тархинд хийсэн анхны, гэхдээ шийдвэрлэх том шалгуур болж түүнд анхны хүн цорын ганц үнэн зөв шийдвэр олж чадсан юм. Тэр бол нүүдэл байлаа. Тэгэхлээр В.Шекспир, Гамлетаараа дамжуулж хүн төрөлхтөний өмнө тавьсан "То be or not to be? буюу "Орших уу, эс орших уу?" гэсэн мөнхийн асуулт үнэндээ Шекспирээс бүр өмнө тавигдсан ёстой өнө мөнхийн асуудал байсан бөлгөө.

Төв Азийн өргөн уудам газар нутгийн нэгээхэн хэсэгт суурьшмал соёл иргэншил улам бүр цэцэглэн хөгжиж байхад нүүдэлчин ард түмнүүд түүнтэй зэрэгцэн мянга мянган онлыг нүүдлийн замд үдэн хорвоог туулсаар байлаа. Олон мянган жилийн тэртээгээс энэхүү их нүүдлийн замаар, байгалийн шалгарлын хуулиар тэдний элэнц дээдэс нь эргэж ирэлгүй нүүн газар дэлхийгээр нэг таран одож тэдний үед хүрч ирэхэд голомтоо сахин үлдсэн нүүдэлчид угсаатны бүрэлдэх үйл явцын босгон дээр түлж ирсэн нь нөгөө талаас нь хэлбэл сүрэлгэсэн анхны хүмүүс, хүй нэгдэл, овгийн байгууллын үеийг бодвол ихээхэн нийгэмжсэн хэрэг байлаа.

Зэрэгцэн оршиж буй мөнөөхөн худалдах ёс, хэрмийнхээ цаана шигдэн суудаг суурин соёл иргэншлийг бодвол тэд аанай л урьдын адил нүүж суусаар л, тэдний нүүдлийн соёл иргэншил улам бүр сонгодог шинжтэй болж, хөгжин хувьссаар байлаа.

Гэтэл чухам энэ л үеэс Их нүүдлийн сонгодог хэлбэрт гадаад хүчин зүйл нөлөөлөх болов. Их нүүдэлд байгалийн шалтгаан төдийлөн аюумшилт, гол чухал хүчин зүйл байхаа больж, гэлээ ч нүүдэлчин ард түмнүүдийн аж төрөх ёсон, амьдралын хэвшил болон заяагдсан тул жамаараа тийн нүүж суусаар мянган онлыг элээж, чанагш нь бас мянга түмэн онлыг туулах тавилантай мэт сэтгэл амгалан сууж атал... гаднын шалтгаан тэднийг аанай л Их нүүдэлд хүргэж, буужигнуулж орхижээ. Нэг үгээр хэлэхэд бидний хэлэх гээд байгаа өнөөх нийгмийн шалгарал гэгч нь түлж ирээд байлаа. Чухам энэ л нийгмийн шалгарал гэгчээс болж Төв Азийн нүүдэлчин ард түмэн нэг бол суурин соёл иргэншилд автан уусч, эс бол түүнээс дүрвэн алс хол нүүдэллэн одох болов.

Чингэхдээ бас л эргэлт буцалтгүй тэр чигтээ наран жаргах зүлт одоцгоосоор байлаа. Энэ талаар нэлээн тодотгож ярилцъя. Бидэнд мэдэгдэж буйгаар Төв Азийн цээжнээ анхлан мандаж, нүүдэлчний анхны төрт улсыг байгуулсан гавъяа Хүн нарт оногдог билээ. Харамсалтай нь тэд мөнөөхөн гайт нийгмийн шалгарлаас ангид байж чадсангүй ээ. Энэ өргөн уудам газар нутаг дээр хүний нийгэм үүсч, хөгжихийн хэрээр нүүдлийн хийгээд, суурьшмал соёл иргэншлүүд энх амгалангаар зэрэгцэн өнө мөнхөд оршин тогтнож болохгүй байв уу? Цаг хугацааны хувьд авч үзвэл харьцангуй богино хугацаанд бол болно, харьцангуй урт хугацааны туршид бол болохгүй байлаа. Энэ нь цаашлаад нийгмийн харилцааны хүчин зүйлүүдтэй холбоотой байв.

Хятадын эртний түүхийн гол сурвалж бичиг болсон "Түүхийн тэмдэглэл"-дээ зохиогч Сы Мацяннь бичихдээ "Тэд бидэнтэй арилжаа хийх хүсэлтэй байдаг. Тэд биднийг өг гэж, бид өгөхгүй гэж ер тэдэнтэй харилцах дургүй тул тэд уулгалан довтлох болов" гэсэн байдаг. Хятадын эртний хаад нэг бус удаа ийм зарлиг буулган, тэр нь нүүдэлчид сөрөг довтлон туйвээх шалтаг болдог байлаа. Бас зөрчилдөх нэг шалтаг бол ихээхэн хуумтай болчимгүй явдлаас нэг бус удаа үүдэж байсныг жишээ татан өгүүлбэл мөнөөх "Түүхийн тэмдэглэл" номдоо "... Тэр үед тэнгис далайн зүг илгээсэн

Лу Шэн эгэн ирж, элдэв сүнс сүлд, тэнгэрийн бошгыг сонгоод, зурхайн мэргийн таавар бичгээс үзүүлвээс тэр нь "Цин улсыг Ху нар (Хүннү) мөхөөмүй" хэмээсэн байсанд Цин Ши хуанди, Мэн Тянь жанжинд гучин түмэн цэрэг өгч умар зүг Хүннүг довтлохоор илгээсэнд тэд Хэнань нутгийн хугасыг (өдгөөгийн Өвөр монголын зарим нутгийг эзлэн аваа. Бас баруун хойш Хүннүг хөөн холтгож Шар мөрнийг уруудуулан дорно зүгт Иншань ууланд тултал хориг болгон их хэрэм босгов. Тийнхүү гучин дөрөвдэх жилдээ (МЭӨ 213 он) эзэн хаан, умарт үй олон боол илгээн Түмэн газрын цагаан хэрмийг байгуулвай..." хэмээн байдаг.

Ийнхүү нүүдэлчдийн өмнө "Орших уу, эс орших уу" гэдэг хүн төрөлхтөний мөнхийн асуулт дахин тавигдав. Хүний нийгэм улам бүр хөгжин цэцэглэсээр байсан энэ үед суурьшмал соёл иргэншил шинэ шинэ давуу талуудыг олж эзэмшиж, харин нүүдэлчин ард түмнүүд байгаль эхтэй хамт байснаараа эрчимт хүчтэй байлаа. Гэвч хүчний харьцаа даанч тэнцвэргүй байв. Тухайлбал манай эриний эхээр Хятадын хүн ам 60 сая байхад нүүдэлчин ард түмнүүд нийлээд гурван сая хүрэхгүй байв. Ийнхүү нэгэн цагт Төв Азийн цээжнээ Номхон далайгаас Хар тэнгис хүртэл, Байгаль нуураас Шар мөрөн хүртэлх асар уудам нутагт хүчирхэгжин мандсан Хүн улс Хятадын их цэргийн удаа дараагийн довтолгоонд арга буюу хүчин мөхөсдөж, дээр нь бас Хятадуудын хатгалгаар Сяньби нар бослого гарган ихэд туйвээсээр манай тооллын өмнөх 48 онд мөхөж Өмнөд Умардад хуваагдсаны Өмнөд Хүн улс нь Хятадын эрхшээлд орж аажмаар хятадчилалдан ууссан юм. Одоо өнөөх гол асуудал маань гарч ирлээ. Өөрөөр хэлбэл Умард Хүн нар яасан бэ? гэдэг асуудал. Умард Хүн нарт хэн шивнээв гэлтэй Их нүүдлийн замд гарч алс баруун зүгт нүүдэллэн одсон агаад тэд Ижил мөрөн хүрч, бас цаашлан Хар тэнгисийн эрэг хөвөөнд хүрч тогтсон нь өдгөө Болгар, Унгар, Герман нарын өвөг дээдэстэй эвсэлдэн нийлж суусан хэрэг билээ.

Хүн нарын дараа Төв Азийн тал нутагт Сяньби нар хүчирхэгжин мандав. Гэвч тэд бас л Хятадад автан мөхөж нэг хэсэг нь тэдэнтэй нийлэн уусаж нөгөө хэсэг нь Нирунтай нийлэн хожим нь Түрэгийн захиргаанд орж, нүүж суусаар байлаа. III-V зууны үед хүчирхэгжин мандсан Нирун улс аанай л Хятадын хүчинд автан мөхөж нэг хэсэг нь Хүн нарын Их нүүдлийн улбаагаар алс баруун

тийш нүүдэллэн одсон юм. Энэ цаг үеэс эхлэн Төв Азийн нүүдэлчин улс түмэн хүний нийгмийн шалтгааны шалгарлаар үргэлжийн Их нүүдлийн замд бүжигнасаар байлаа. Нэгэн цагт хүчирхэг явсан Түрэгийн хаант улс Хятадын Тан улсад автан мөхөж нэг хэсэг нь тэдний цусыг сэлбэн уусаж нөгөө хэсэг нь үндэс угсаагаа авран үлдээхийн эрхээр дүрвэн баруун тийш нүүдэллэж Истанбул хэмээх газар хүрч тогтносоор өнөөдөр дэлхийн хөгжингүй арван орны нэг болж үнэхээр үндэс угсаагаа мөхөөлгүй авран гарч чаджээ.

Уйгар, Хотон, Хиргис, Авар, Хатан нар мөн л тийм хувь заяа эдэлснийг нуруших нь илүүц буй заа. Монгол угсааны Хатан нар Х зуун хүртэл оршин тогтноод нэг хэсэг нь Хятадад уусч аргаа барахдаа нэр усаа хүртэл тэдэнд үлдээгээд холдож нүүсэн билээ. Өнөөгийн бидний хэлдэг хятад гэдэг нэр бол угтаа Монгол угсааны Хатан нарын алдар байсан боловч тэд өмнө зүгийн тариачин Нанхиадад эргийзжэн уусмагц нь бусад нүүдэлчин улс түмэн тэднээс жийрхэн хөндийрч хоёуланг нь Хятад гэж нэрлэсэн нь түүхийн гашуун үнэн амой.

Ийнхүү нийгмийн шалгарлаас шалтгаалсан Их нүүдлүүд тасралтгүй үргэлжилсээр Х зууныг угтсан юм. Х зуунд Зүүн Хойд Азид хүчирхэг тогтсон Зүрчидийн Алтан улс удалгүй мөхсөн нь Манж угсаатан Хятадад ууссан гурван удаагийн эмгэнэлт түүхэн үйл явдлын эхэн байв. Бурхан багшийн үнэнч шавь тэнгэрт суудалтай Түвд үндэстэн VI-VII зуунаас Хятадын хялганд өртөх болж, хүлцэнгүй номхоны туйлыг үзүүлсээр өнөөдөр хүн төрөлхтөний нүдэн дээр харсаар атал хайлан уусч байна. Энэ мэтчилэн Уйгур, Хотон, Чантуу ... гээд олон үндэстэн ястан тун бүрхэг дүр төрхтэй байсаар байгаа билээ.

Нийгмийн шалгарлаас шалтгаалсан Их нүүдлийн түүхийг ийнхүү базан үзвээс мөнөөхөн "Орших уу, эс орших уу" хэмээсэн мөнхийн асуултын шийдэл гарч ирэх бөгөөд үүнд товчхон нэг үгээр хариулахад "Нүү! Нүүвэл оршин тогтоно. Эс нүүвэл уусаж үгүй болно" гэсэн хариу гарч байна. Тиймээ Хүн нарын хагас нь нүүсэн. Түрэгийн хагас нь нүүж амь гарсан. Нирун, Сяньби, Хатан, Хиргис, Уйгар ... гээд ихэнх нь нүүн одсоор л байсан. Тэр ч байтугай саахны жишээ гэхэд Баруун Монголчууд чухам энэ л шалгарлын хуулиар XVI зууны үед нүүн оджээ. Гэхдээ нүүхэд учир бий. Нүүвэл нүүсэн

шиг нууж, холдвол холдсон шиг холдох хэрэгтэй аж. Тэгээгүйгээс болж Уйгар, Хотон, Тангад-Түвд, бас Монгол угсаатай Хөхнуур, Түвдийн Монголчууд бэлчээр сэлгэн бууж яваа малчдын нүүдэл мэт хава хатган бууснаас болж, өнөөдөр хаана, хэний хилийн дээсэнд, хэний хатавчинд хүлээтэй суугаа нь илэрхий байгаа буй заа ...

Их нүүдэл хүн төрөлхтөний түүхийн аль ч цаг үед шил шилээ даран үргэлжилсээр иржээ. Тэдгээрийн цөөн заримаас дурдвал, Баруун Энэтхэг хэмээн андуурч, Америк тивийг нээсэн Христофор Колумбын аяллын үр дүнд монголжуу-индианчуудын хязгааргүй ноёрхол төгсч Европоос Америкийг чиглэсэн колоничлогчдын Их нүүдэл бүтэн гурван зууны турш тасраагүйгээр үл барам өнөө ч үргэлжилсээр байна гэж хэлж болох юм. Үүний дараахан шинэ тивд суурьшсан колоничлогчид ажлын хямд хүч хэмээн Хар Африкаас сая сая боол худалдан авч, тийш нь бас нэг их нүүдлийн зам гаргажээ. Үүнтэй бараг зэрэг шахам английн далайчид Австрали тивд хөл тавьж, хатан хааныхаа эзэмшил болгон өмчилж, эрзэн далаагаа мандуулснаар монголжуу-абориген (уугуул иргэд)-ий ноёрхол дуусч цагаан арьстны их нүүдэл тэр зүгт цутгажээ. Энэ мэтчилэн Канад, Гренландад Франц англичууд нүүн суурьшиж, Бразилийн ширэнгэ, Амазонкийн шугуй руу Испани, Португалийн конкистадоруд улангассан бүхын дайралтаас дүрвэх мэт хуйлран одоцгоож, Малайз, Филиппин рүү энэтхэгчүүдийн нүүдэл цувж, умард туйлаас бусад хуурай газар дээр хужаа цагаачдын шаахайн мөр гарчээ.

Тэр ч атугай ХХ зууныг сайн муугаар ихээхэн донсолгосон сүрт Октябрийн эргэлтийн дуулианаар олон сая цагаан орос, украин, белорусь, польш, армян хүмүүс цацсан будаа мэт дэлхийгээр нэг тарж, суулдхэн дэлхийн хоёрдугаар дайны хөлөөр зовлонт еврей нар дайжин ийш тийш шидэгдэж байсан бол өнөөдөр тэд Бага-Азид олж авсан алга дарам газрынхаа зүг ертөнцийн зах хязгаараас цутган тэмүүлцгээж байна. Ганц, хоёрхон жилийн дараа эх газрын Коммунист Хятадад эргэн нэгдэхээр болсон Хонконг болоод Макао хэмээх хот улсуудын иргэд коммунизмын талхинд дэглүүлэхээс жийрхэж, оройтоогүй дээрээ амиа бодохоор хөөгөө зөөх хээрийн бор хулгана мэт хандсан зүгтээ хөрөнгө зоорио зөөн нүүж эхлээд байгаа билээ.

Ийнхүү эцэст нь дүгнэн хэлэхэд хүн төрөлхтөний түүх бол Их нүүдлийн түүх мөн ажгуу. Хүн гээч хоёр хөлтэй, хохимой толгойтой, оюун ухаан гэгч гайхамшигийг эзэмшсэн бодгаль амьтан Дэлхий дээр төрж, мэндэлсэн тэр цагаас эхлэн үргэлжид нүүн суусаар өнөөг хүрч иржээ. Байгаль болоод нийгмийн шалгарлаар явагдаж ирсэн энэхүү Их нүүдэл гэгч эргээд байгаль болоод нийгэмд нөлөөлөн харилцан шалтгаалцаж, Дэлхийн түүхийг Их нүүдлийн замд туурвин бүтээсээр байнам.

Коммунизмын онолч Владимир Ленин нэгэнтээ "Өнөөг хүртэлх хүн нийгмийн түүх бол ангийн тэмцлийн түүх мөн" хэмээн үзэл сурталжсан томъёололоор онолдсон байдаг. Чингэхүл үзэл суртлаас ангид, аливаа нэгэн санаанаас зохиосон онол цэцэрхтээс ангид, жамаараа яваа ертөнцийн хуулиар хүн төрөлхтөний түүх "Их нүүдлийн" замыг туулжээ.

Харин өнөөдрийн Монгол үндэстэн чингэж Их нүүдлийн замд шуудран хөдлөөгүй атлаа туурга оршин тогтносоор буйн учир юун хэмээвээс ганц үгээр өнөөдрийн Монгол бол Эрчимт үндэстэн мөн" гэсэн үгээр төгсгөө.